

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/50/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: [khuanganm@audit.gov.mn](mailto:khuanganm@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: [jenisbekh@audit.gov.mn](mailto:jenisbekh@audit.gov.mn)

“Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: Б.Галымбек

Утас: 99101563 Цахим хаяг: [uujimaudit@gmail.com](mailto:uujimaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	16
3.4 Материаллаг байдал .....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	19
3.8 Аудитын гол асуудал .....	20
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	20
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	20
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	21
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
4. Аудитын илрүүлэлт .....	21
4.1 Залруулсан алдаа .....	21
4.2 Төлбөрийн акт .....	21
Байхгүй .....	21
4.3 Албан шаардлага .....	21
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	23

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgiu@audit.gov.mn

**БУЛГАН СУМЫН ЁЛТ ХҮҮХДИЙН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
К.ЗЕРДЕГҮЛ ТАНАА**

2022.02.21 № 97  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

Дүгнэлт-Булган Ёлт цэцэрлэг-2.20

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

Дүгнэлт-Булган Ёлт цэцэрлэг-2.20

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>25303266.76</u></b>	<b><u>24284133.26</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	4555185.00	2177949.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4528578.00	2177949.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	26607.00	0.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	26607.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	20748081.76	22106184.26
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	23200.00	0.00
35130	Эм боох материал	23200.00	0.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	20724881.76	22106184.26
35420	Аж ахуйн материал	10045102.00	11128504.00
35440	Түлш, шатах тослох материал	4076493.00	4686600.00
35460	Хүнсний материал	6603286.76	6291080.26
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>30706980.48</u></b>	<b><u>28918911.70</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	30706980.48	28918911.70
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	25706980.48	23918911.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	17013723.30	17013723.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	-972212.88	-1458319.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11182500.00	8632500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2620141.65	-1218641.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2434420.00	1591620.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1331308.29	-641970.67
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	5000000.00	5000000.00
39301	Програм хангамж	550000.00	550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	-550000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5000000.00	5000000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>56010247.24</u></b>	<b><u>53203044.96</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>56010247.24</u></b>	<b><u>53203044.96</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	56010247.24	53203044.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5933080.00	5933080.00
51101	Өмч: - төрийн	5933080.00	5933080.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	50077167.24	47269964.96
51210	Өмнөх үеийн үр дүн	50077167.24	50077167.24
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-2807202.28
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>56010247.24</u></b>	<b><u>53203044.96</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>145,965,040.00</b>	<b>142,506,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,032,440.00</b>	<b>-</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,032,440.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	7,032,440.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,032,440.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>138,932,600.00</b>	<b>142,506,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	138,932,600.00	142,356,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,597,700.00	7,922,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	131,334,900.00	134,433,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	150,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	150,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>134,991,856.31</b>	<b>145,313,202.28</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>134,991,856.31</b>	<b>145,313,202.28</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	133,973,218.31	145,047,428.28
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	103,414,947.00	108,412,587.00
210101	Үндсэн цалин	94,522,214.00	99,663,487.00
210104	Урамшуулал	8,892,733.00	8,749,100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	12,839,685.00	14,698,825.00
210201	Тэтгэврийн даатгал	7,782,762.00	8,819,295.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,330,768.00	1,469,885.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,064,618.00	1,175,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	293,975.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,661,537.00	2,939,770.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8,158,949.50	7,422,186.00
210301	Гэрэл, цахилгаан	814,400.00	989,043.00

210302	Түлш, халаалт	7,344,549.50	6,433,143.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,365,100.50</b>	<b>3,717,350.00</b>
210401	Бичиг хэрэг	-	159,500.00
210402	Тээвэр, шатахуун	566,000.50	1,279,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	60,000.00	456,000.00
210404	Ном, хэвлэл	-	25,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	739,100.00	1,494,700.00
210408	Бараа материал акталсны зардал	-	303,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>6,888,745.34</b>	<b>7,253,411.50</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	83,440.00	45,500.00
210502	Хоол, хүнс	6,570,305.34	7,026,513.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	235,000.00	181,398.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>331,000.00</b>
210604	Урсгал засвар	-	331,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>-</b>	<b>111,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	-	111,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>300,000.00</b>	<b>291,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	41,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,005,790.97</b>	<b>2,808,568.78</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	56,000.00	1,020,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	949,790.97	1,788,068.78
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,018,638.00</b>	<b>265,774.00</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,018,638.00</b>	<b>265,774.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,018,638.00	265,774.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>10,973,183.69</u></b>	<b><u>(2,807,202.28)</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>10,973,183.69</u></b>	<b><u>(2,807,202.28)</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	84,669,950.00	106,704.00	1,263,130,133.67	1,347,906,787.67
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>84,669,950.00</b>	<b>106,704.00</b>	<b>1,263,130,133.67</b>	1,347,906,787.67
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн	10,960,000.00			10,960,000.00
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,933,080.00</b>	<b>0.00</b>	<b>50,077,167.24</b>	56,010,247.24
D01	<b>2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>5,933,080.00</b>	<b>0.00</b>	<b>50,077,167.24</b>	56,010,247.24
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>5,933,080.00</b>	<b>0.00</b>	<b>50,077,167.24</b>	56,010,247.24
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-2,807,202.28	-2,807,202.28
D09	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,933,080.00</b>	<b>0.00</b>	<b>47,269,964.96</b>	53,203,044.96

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>138932600.00</b>	<b>142506000.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>138932600.00</b>	<b>142506000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	138932600.00	142356000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7597700.00	7922400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	131334900.00	134433600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	150000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		150000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>138654100.00</b>	<b>142506000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>138654100.00</b>	<b>142506000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>137635462.00</b>	<b>142240226.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	103512762.00	105776183.00
210101	Үндсэн цалин	94620029.00	97027083.00
210104	Урамшуулал	8892733.00	8749100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14359300.00	14990600.00
210201	Тэтгэврийн даатгал	10104800.00	10548900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1063600.00	1110400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	850900.00	888400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	212700.00	222100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2127300.00	2220800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7597700.00	7712043.00
210301	Гэрэл, цахилгаан	1563700.00	1088043.00
210302	Түлш, халаалт	6034000.00	6624000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3550200.00	5838000.00
210401	Бичиг хэрэг	209300.00	111600.00
210402	Тээвэр, шатахуун	2693500.00	1698300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	134000.00	456000.00
210404	Ном, хэвлэл	25100.00	25100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	488300.00	3547000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	7824600.00	6891400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50000.00	22300.00
210502	Хоол, хүнс	7513000.00	6687700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	261600.00	181400.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.00	210000.00
210604	Урсгал засвар	0.00	210000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.00	111600.00
210702	Дотоод албан томилолт	0.00	111600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	300000.00	291900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	41900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300000.00	250000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	490900.00	418500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	490900.00	418500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1018638.00</b>	<b>265774.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1018638.00	265774.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1018638.00	265774.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>278500.00</u></b>	<b><u>0.00</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>0.00</u></b>	<b><u>0.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	278500.00	0.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

Төгрөгөөр

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	142356000.00	142090226.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	142356000.00	142090226.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	142356000.00	142090226.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	106041000.00	105776183.00
210101	Үндсэн цалин	97291900.00	97027083.00
210104	Урамшуулал	8749100.00	8749100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14990600.00	14990600.00
210201	Тэтгэврийн даатгал	10548900.00	10548900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1110400.00	1110400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	888400.00	888400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	222100.00	222100.00

210205	Эрүүл мэндийн даатгал	2220800.00	2220800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7712400.00	7712043.00
210301	Гэрэл, цахилгаан	1088400.00	1088043.00
210302	Түлш, халаалт	6624000.00	6624000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5688600.00	5688000.00
210401	Бичиг хэрэг	111600.00	111600.00
210402	Тээвэр, шатахуун	1698300.00	1698300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	456000.00	456000.00
210404	Ном, хэвлэл	25100.00	25100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3397600.00	3397000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	6891400.00	6891400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22300.00	22300.00
210502	Хоол, хүнс	6687700.00	6687700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	181400.00	181400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	210000.00	210000.00
210604	Урсгал засвар	210000.00	210000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	111600.00	111600.00
210702	Дотоод албан томилолт	111600.00	111600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	291900.00	291900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41900.00	41900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250000.00	250000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	418500.00	418500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	418500.00	418500.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	142356000.00	142356000.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	134433600.00	134433600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	134433600.00	134433600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан хөрөнгө	150000.00	150000.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	7922400.00	7922400.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	7922400.00	7922400.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	11.00	12.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	5.00
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00

Төгрөгөөр

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>150000</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>150000</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	150000
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	150000
210405	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	150000
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	150000
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	150000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	150000
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Ужиг алтай Аудит” ХХК-ны аудитор Б.Галымбек гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Аймгийн боловсролын газрын 2021-2022 оны хичээлийн жилийн зорилтыг үндэслэн хүүхэд бүр сурч хөгжих таатай орчин бүрдүүлэх зорилгоор дараах зорилтыг дэвшүүлсэн ажлилласан байна. Үүнд:

1. Цэцэрлэгийн үйл ажиллагааг түр журмын дагуу төлөвлөж ажиллах.

2. Багш ажилтныг стрессээс сэргийлэх сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёл бүрдүүлэх.
3. Цэцэрлэгийн үйл ажиллагааг хүүхдийн онцлог ялгаатай хэрэгцээнд тулгуурлан амжилттай суралцах, хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөлт ажил арга хэмжээг нутгийн захиргааны байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоотой зохин байгуулах, хамтын ажиллагаа түншлэлийг идэвжүүлэх.
4. Өдөр бүр хүүхдийн биеийн байдалыг шалгаж, халууныг хэмжих, цэцэрлэгт гадааны хүн оруулахгүй байх.
5. Цэцэрлэгийн эрхлэгч, багш, туслах багшийг чадваржуулах, монгол хэлний мэдлэгийг дээшлүүлэн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах.
6. Цэцэрлэгийн үйл ажиллагааг танхимын болон зайны сургалтын хөтөлбөрийг хослон авч явуулах.
7. Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтыг 0.2-0.5 хувиар нэмэгдүүлэх.
8. Цэцэрлэгийн ариун цэвэрт анхаарч хүүхдийн хоол хүнсний аюулгүй байдал, шим тэжээл, чанарыг сайруулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдсэн байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 134.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 2.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.8 сая төгрөгөөр буюу 5.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		0.00	0.00
Авлага	4555.2	2177.9	-2377.3
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	20748.1	22106.2	1358.1
Үндсэн хөрөнгө	30706.9	28918.9	-1788.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>56010.2</b>	<b>53203.0</b>	<b>-2807.2</b>
Өр төлбөр		0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	<b>56010.2</b>	<b>53203.0</b>	<b>-2807.2</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>56010.2</b>	<b>53203.0</b>	<b>-2807.2</b>

Авлага дансны үлдэгдэл 2.1 сая төгрөг болж 2.4 сая төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 22.1 сая төгрөг болж 1.4 сая төгрөгөөр өссөн нь хүнсний материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой байна. Хүнсний материал данс 6.2 сая төгрөгийн, түлш, шатах тослох материал 4.9 сая, аж ахуйн материалын данс 11.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна

Оны эхэнд 6.6 сая төгрөгийн хоол, хүнсний материалын үлдэгдэлтэй байсан ба 6.7 сая төгрөгийн хүнс худалдан авч 4.6 сая төгрөгийн материалыг зарцуулж. Мал эмнэлгийн улсын байцаагчийн 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 40-02-171-/1 тоот акт, Булган сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 39 дүгээр тогтоолын дагуу 2.4 сая төгрөгийн хүнсний материалыг акталж, жилийн эцэст 6.3 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй гарснаас үзэхэд хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлсөн нь цэцэрлэгийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой чанар байдал алдаж муудах эрсдэлтэй байна.

Үдсэн хөрөнгө дансны үлдэгдэл 28.9 сая төгрөг болж 1.8 сая төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын 2021 оны 133 дугаар тогтоолын дагуу 3.4 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасаж, үндсэн хөрөнгөнд 1.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлжээ.

Тайлант оны эцэст өр төлбөргүй байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 158.6 сая төгрөг, тодотгосон төсөв 142.3 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 16.3 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Үүнд: Хангамж, бараа материалын зардалыг 3.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, цалин, хөлс, нэмэгдэл урамшилийн зардлыг 7.0 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 0.3 сая төгрөгөөр, норматив зардал буюу хоолны зардалыг 11.9 сая төгрөгөөр анх баталсанаас буруулж тодотгосон байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 142.3 сая төгрөгийн төсөв баталснаас 134.4 сая төгрөгийг улсын төсвөөс 7.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 142.3 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаандаа 142.1 сая төгрөгийг зарцуулж, 0.2 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 0.2 хэмнэсэн байна.

Нийт төсвийн 74.5 хувийг цалин, 10.4 хувийг НДШ-ийн зардал, 5.4 хувийг тогтмол зардал, 4.0 хувийг хангамж бараа материалын зардал, 4.8 хувийг нормативт зардал, 0.1 хувийг урсгал засварын зардал, 0.2 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 0.4 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 0.15 сая төгрөгийн нэмэлт төсөв авч хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгахад зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардалд 106.0 сая төгрөг, НДШ-ийн зардалд 14.9 сая төгрөг, халаалтын зардалд 7.7 сая төгрөг, урсгал засвар, эмийн зардалд 0.2 сая төгрөг, хоолны зардалд 6.7 сая төгрөг, нийтдээ 135.5 сая төгрөг зарцуулсан байна.

Нийт санхүүжилтийн 142.3 сая төгрөгнөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлыг хасахад 6.8 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд

тогтоолын дагуу 0.6 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба оны эцэст 0.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн тул Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдсан гэж үзлээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий дараах ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2021 онд нийт 142.2 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 142.2 төгрөгийн 144 мэдээллийг хугацаандаа байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, 2 мэдээллийг буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулах хугацаа болоогүй байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайланд 4.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэхгүйгээр нийгмийн даатгалын шимтгэлд авлага үүсгэсэн зөрчилд албан шаардлага өгсөн ба давтан шалгаж үзэхэд авлагыг 2.1 сая төгрөг болгож багасгаж албан шаардлагыг дутуу хэрэгжүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Хүнсний материалын үлдэгдэл их хэмжээгээр нөөцөлсөн нь анхаарах асуудал байна гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар алдаа зөрчил илэрээгүй байна.

#### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй

#### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй

#### 4.3 Албан шаардлага

Байхгүй

#### 4.4 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1											